



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /1/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.08.15 № 97
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН
АВТОТЭЭВРИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН
ДАРГА Б. АРИУНСАЙХАН ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Нийт орлого төлөвлөснөөс 46,839.83 мянган төгрөгөөр буюу 108.5 хувиар давж биелсэн бөгөөд нэр төрлийн хувьд хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн орлого 8%-иар, орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн орлого 4%-иар тасарсан нь 1-5 сарын хугацаанд хот хоорондын тээвэр зогссонтой холбоотой байна.

Нийт 454,884.79 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 12,327.4 төгрөгийг хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны зардалд хэмнэлт гаргаж дээд шатны төсвийн захирагчид төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,080,149.87	67,155,447.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	60,027.90	48,496.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	60,027.90	48,496.75
3121	Төгрөг	60,027.90	48,496.75
31213	Арилжааны банк дахь харилцах	60,027.90	48,496.75
34	УРЬДЧИЛГАА	31,314,391.00	31,314,391.00
34400	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	31,314,391.00	31,314,391.00
35	БАРАА МАТЕРИАЛ	33,705,730.97	35,792,559.67
351	Түүхий эд материал	5,529,689.48	5,351,569.71
35110	Тусгай зориулалттай материал	5,529,689.48	5,351,569.71
354	Хангамжийн материал	28,176,041.49	30,440,989.96
35410	Бичиг хэргийн материал	410,499.99	397,727.26
35420	Аж ахуйн материал	3,744,587.79	4,037,906.11
35430	Сэлбэг хэрэгсэл	10,020,092.71	10,020,092.71
35440	Түлш, шатах тослох материал	163,636.36	-
35470	Бусад хангамжийн материал	13,837,224.64	15,985,263.88
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	900,796,187.71	845,043,163.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	900,796,187.71	845,043,163.57
392	Биет хөрөнгө	707,356,187.71	651,603,163.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	572,045,389.29	572,045,389.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,380,097.37)	(39,847,808.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,921,121.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,921,121.00)	(208,333.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,253,845.36	200,520,888.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(107,167,465.03)	(156,657,419.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,205,613.30	17,205,613.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,509,998.42)	(9,929,494.52)
39214	Бусад үндсэн хөрөнгө	127,908,900.58	74,551,666.58
39215	Хуримтлагдсан элэгдэл		(11,077,337.58)
393	Биет бус хөрөнгө	193,440,000.00	193,440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	193,440,000.00	193,440,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	965,876,337.58	912,198,610.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	924,553,176.41	912,198,610.99
51	Засгийн газрын хувь оролцоо	924,553,176.41	912,198,610.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	488,560,301.12	-
51101	Өмч: - төрийн	488,560,301.12	-
512	Хуримтлагдсан үр дүн	435,992,875.29	907,198,610.99
51210	Өмнөх үеийн үр дүн	379,310,457.24	767,900,685.94
51220	Тайлант үеийн үр дүн	56,682,418.05	139,297,925.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		5,000,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	924,553,176.41	912,198,610.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Орхон аймгийн Автотээврийн төв ТАУГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	485,207,495.68	596,364,533.16
11	ТАТВАРЫН ОРЛОГО	473,564,024.54	583,105,354.23
110	Орлогын албан татвар	473,564,024.54	583,105,354.23
1100	Хувь хүний орлогын албан татвар	473,564,024.54	583,105,354.23
110002	Үйл ажиллагааны орлого	473,564,024.54	583,105,354.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,643,471.14	13,259,178.93
120	Нийтлэг татварын бус орлого	11,643,471.14	13,259,178.93
120002	Хүүгийн орлого	123,898.45	-
120005	Түрээсийн орлого	11,372,727.18	11,909,090.91
120009	Бусад орлого	146,845.51	1,350,088.02
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	428,525,077.63	457,066,608.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,525,077.63	457,066,608.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,875,077.63	436,619,979.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,541,770.19	308,819,144.70
210101	Үндсэн цалин	287,330,270.19	292,152,144.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,211,500.00	16,667,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,916,250.80	43,120,739.20
210201	Тэтгэврийн даатгал	25,762,083.84	27,150,095.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,424,666.72	2,555,303.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,061,666.78	6,388,257.66
210204	Ажилгүйдлийн даатгал	606,166.68	638,825.77
210205	Эрүүл мэндийн даатгал	6,061,666.78	6,388,257.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,627,147.25	20,213,429.01
210301	Гэрэл, цахилгаан	3,273,334.55	4,232,407.97
210302	Түлш, халаалт	6,614,466.36	6,767,125.94
210303	Цэвэр, бохир ус	1,616,553.56	1,855,553.26
210304	Байрны түрээс	8,122,792.78	7,358,341.84
2104	Хангамж, бараа материалын зардал	7,216,813.23	11,481,472.97
210401	Бичиг хэрэг	1,959,931.57	2,084,181.82
210402	Тээвэр, шатахуун	2,375,076.36	3,788,454.55
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,689,805.30	2,443,182.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	192,000.00	2,028,181.82
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		1,137,472.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,505,878.55	9,197,336.26
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,024,060.37	8,925,518.08
210604	Урсгал засвар	481,818.18	271,818.18
2107	Томилолт, зочны зардал	768,000.00	-
210702	Дотоод албан томилолт	768,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,067,031.01	11,013,415.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	364,300.00	364,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,840.00	1,007,340.91
210804	Тээврийн хэрэгслийн татвар		171,080.00
210807	Газрын төлбөр	290,160.00	290,160.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	420,913.50	109,987.95
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,975,817.51	2,683,346.14
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	3,080,000.00	3,080,000.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	4,722,000.00	3,307,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,232,186.60	32,774,441.97
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,232,186.60	32,774,441.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,650,000.00	20,446,629.00

Орхон аймгийн Автотээврийн төв ТАҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,650,000.00	20,446,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,650,000.00	20,446,629.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,682,418.05	139,297,925.05
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,682,418.05	139,297,925.05

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,342,457.84	0.00	379,310,457.24	966,652,915.08
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,342,457.84	0.00	379,310,457.24	966,652,915.08
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(98,782,156.72)	0.00	0.00	(98,782,156.72)
C07	Тайлант үеийн үр дүн			56,682,418.05	56,682,418.05
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	488,560,301.12	0.00	435,992,875.29	924,553,176.41
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	389,778,144.40	0.00	435,992,875.29	825,771,019.69
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	488,560,301.12	0.00	435,992,875.29	924,553,176.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(488,560,301.12)	0.00	331,907,810.65	(156,652,490.47)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	5,000,000.0	0.00	5,000,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			139,297,925.05	139,297,925.05
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	5,000,000.0	907,198,610.99	912,198,610.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,419,073,610.65	1,044,021,574.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,017,951,272.00	610,250,177.00
110	Орлогын албан татвар	1,017,951,272.00	610,250,177.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,017,951,272.00	610,250,177.00

Орхон аймгийн Автотээврийн төв ТАУГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

110002	Үйл ажиллагааны орлого	493,266,680.00	243,526,999.00
110008	Шууд бус орлого	524,684,592.00	366,723,178.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	401,122,338.65	433,771,397.00
120	Нийтлэг татварын бус орлого	401,122,338.65	433,771,397.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	389,822,338.65	420,671,397.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	389,822,338.65	420,671,397.00
120005	Түрээсийн орлого	11,300,000.00	13,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,421,852,685.47	1,044,033,105.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,421,852,685.47	1,044,033,105.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,523,276.79	405,660,341.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,501,520.19	307,596,296.93
210101	Үндсэн цалин	277,634,603.82	278,543,667.11
210102	Нэмэгдэл	9,655,416.37	14,146,129.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,211,500.00	14,906,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,916,250.80	46,127,386.97
210201	Тэтгэврийн даатгал	40,916,250.80	46,127,386.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,290,309.90	21,880,755.89
210301	Гэрэл, цахилгаан	3,600,668.00	4,655,648.77
210302	Түлш, халаалт	7,275,912.79	7,293,929.77
210303	Цэвэр, бохир ус	1,778,209.11	2,191,017.35
210304	Байрны түрээс	8,635,520.00	7,740,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,829,619.84	6,218,803.41
210401	Бичиг хэрэг	1,029,650.00	1,280,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,792,584.00	3,974,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,007,385.84	964,803.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,176,002.56	9,974,220.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,176,002.56	9,974,220.00
2107	Томилолт, зочны зардал	1,648,000.00	2,400,000.00
210702	Дотоод албан томилолт	768,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	880,000.00	2,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,881,573.50	4,829,587.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	448,500.00	-
210807	Газрын төлбөр	290,160.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	420,913.50	109,587.95
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	4,722,000.00	4,720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,280,000.00	6,633,290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,280,000.00	6,633,290.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,031,329,408.68	638,372,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,590,000.00	20,446,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,590,000.00	20,446,629.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	506,099,816.68	617,926,135.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	506,099,816.68	617,926,135.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	523,639,592.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	523,639,592.00	-

Орхон аймгийн Автотээврийн төв ТАУГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(2,779,074.82)</u>	<u>(11,531.15)</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	123,898.45	-
140007	Хүлээн авсан хүүний орлого	123,898.45	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>123,898.45</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2,655,176.37)	(11,531.15)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,715,204.27	60,027.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,027.90	48,496.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,116,348.00	421,203,130.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,116,348.00	421,203,130.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,116,348.00	400,756,501.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,606,400.00	307,596,296.93
210101	Үндсэн цалин	295,832,000.00	278,543,667.11
210102	Нэмэгдэл	20,102,400.00	14,146,129.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,672,000.00	14,906,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,880,428.00	46,127,386.97
210201	Тэтгэврийн даатгал	48,880,428.00	46,127,386.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,869,200.00	21,880,755.89
210301	Гэрэл, цахилгаан	2,484,800.00	4,655,648.77
210302	Түлш, халаалт	7,000,000.00	7,293,929.77
210303	Цэвэр, бохир ус	1,980,000.00	2,191,017.35
210304	Байрны түрээс	9,404,400.00	7,740,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,438,000.00	6,218,803.41
210401	Бичиг хэрэг	2,400,000.00	1,280,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,050,000.00	3,974,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,000.00	964,803.41
210404	Ном, хэвлэл	128,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,320,000.00	9,974,220.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,320,000.00	9,974,220.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,802,320.00	6,728,037.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,490,160.00	1,608,290.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,722,000.00	4,720,000.00
210807	Газрын төлбөр	290,160.00	290,160.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	109,587.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	2,231,000.00

Орхон аймгийн Автотээврийн төв ТАҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	2,231,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	20,446,629.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	20,446,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	20,446,629.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	420,671,397.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	420,671,397.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	420,671,397.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		60,027.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,496.75

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 101 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ нь нэн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зорилго нь компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах үүднээс өр авлага, үргүй зардлыг багасгах, хөрөнгө хүн хүч, техникийн боломждоо тулгуурлан ажлын байр шинээр бий болгох, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилтан, ажилчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, үр ашигтай тогтвортой үйл ажиллагааг явуулах зорилготой ажиллаж байна.

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ 2005 байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд

өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- Хөдөлмөрийн тухай хууль 2022 оны 01 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчингүй шинэ хууль мөрдөгдөнө.
- Татварын хууль тогтоомж
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТХууль
- Төрийн албаны тухай хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 553,400.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,534.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,873.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ нь санхүүгийн Unicus программыг ашигладаг бөгөөд тус программд нэвтрэх 1 эрхтэй ажилтантай ерөнхий нягтлан бодогч, нярав нар өдөр тутмын ажил гүйлгээг оруулж байна.

Харин тус программд үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй оруулахдаа эд хариуцагч бүрийн нэрийг хөрөнгө бүрийн ард тусгаж өгсөн нь хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,354.59 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	60.02	48.49	(10.53)
Авлага	0	0	0
Урьдчилгаа	31,314.4	31,314.4	0
Бараа материал	33,705.73	35,792.56	2,086.83
Үндсэн хөрөнгө	666,033.0	651,603.16	(14,426.84)
Нийт хөрөнгө	924,553.2	912,198.61	(12,354.59)
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	924,553.2	912,198.61	(12,354.59)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	924,553.2	912,198.61	(12,354.59)

Бараа материалын дансны үлдэгдэл 35,792.56 мянган төгрөг болж 2,086.83 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал болон хангамжийн материалыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-с хоорондын тооцоогоор авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 651,603.16 мянган төгрөг болж 14,426.84 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд АТҮТөвд “Nissan teana” маркийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 37,173.58 мянган төгрөгийн өртөгтэй, 37,173.58 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй суудлын автомашин хоорондын тооцоогоор шилжүүлсэнээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ нь нийт 549,524.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 596,364.53 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 8,5 хувиар давж биелсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг байдлын өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг

оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын хүрээнд төсвийг зарцуулж 12,327.39 мянган төгрөгийн хэмнэлтийг дээд шатны төсвийн захирагчид төвлөрүүлсэн байна.

3.8. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 549,524.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагч тухайн байгууллагын төсвийн төслийг 467,212.18 мянган төгрөгөөр баталж зарцуулах эрх олгосон байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 454,884.79 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 12,327.39 мянган төгрөгийн хэмнэлтийг дээд шатны төсвийн захирагчид төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Тус байгууллага нь улсын төсөвт 549,524.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 596,364.53 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 108,5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Техникийн хяналтын үзлэг	383,000	427,050.68	44,050.68	111.5
Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн 8%	64,243.9	33,128.9	(31,115.0)	(48.44)
Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн 4%	21,200.8	4,029.69	(17,170.31)	(81)
Түрээсийн орлого	12,000.0	11,909.09	(90.91)	(0.76)
Бүртгэлийн үйлчилгээний орлого	68,780.0	116,835.09	48,055.09	169.8
Бусад орлого		1,350.0	1,350.0	
Бусад орлого/бүртгэл/	300.0	2,061.0	1,761.0	
Нийт орлогын дүн	549,524.7	596,364.53	46,839.0	8.5

Төвлөрүүлэх орлого нийт дүнгээрээ 46,839.0 мянган төгрөгөөр давж биелэсэн ч хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн 8%, орон нутгийн зорчигч тээвэрлэлтийн 4%, түрээсийн орлого тасарсан нь 1-5 сарын хугацаанд хот хоорондын тээвэр зогссонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ нь нэмэлт санхүүжилтийн дансгүй болно.

3.9 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.10 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.11 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.11.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ нь 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 150 мэдээлэл бүрэн мэдээлж 1 мэдээ хугацаа хоцроосон байна.

3.11.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 34.3.2-д "тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй", хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,081.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	3	3,081.7	3	3,081.7	0	0	0
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Нийт дүн	3	3,081.7	3	3,081.7	0	0	0

3.13 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,020.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,020.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа: Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт: Байхгүй.

4.3 Албан шаардлага: Байхгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 480.0 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

1.3. Илрүүлэлт:

Орхон аймгийн Автотээврийн төв ТАҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг шилжүүлэхдээ гэрээ хэлцэл хийлгүй 2,540.0 мянган төгрөгийг шилжүүлсэн /Баян-Өндөр мед эмнэлэг,"Уран сархиа" ХХК/ байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 34.3.2-д "тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.4. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарцуулалтын үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс ажил үйлчилгээ авахдаа гэрээ байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Автотээврийн төв ТӨҮГ	2	3,020.0	0	0	0	0	0	0	2	3,020.0